



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Эрхүүгийн гудамж, 7 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14192
Утас: 7703 2222, 7777 2001,
Цахим шуудан: info@gadpwd.gov.mn,
Цахим хуудас: www.gadpwd.gov.mn

2025.02.20 № 2/112
танай _____-ны № _____-т

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА С.ТӨМӨРХҮҮ ТАНАА

Хамтран ажиллах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн хурал 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж Үндэсний зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг баталсан.


Мөн 2025 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгосон тул тус яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл үйл ажиллагаагаа идэвхжүүлэн салбарын онцлог, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төлөвлөөг гарган баталж, зөвлөлийн бүрэлдэхүүнээ шинэчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажлын алба Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт ирүүлж хамтран ажиллана уу.

Жич: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн тогтоол, 2025 оны төлөвлөгөөг хавсаргав.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.БАУЫРЖАН



14250235



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө, зөвлөмж, албан даалгавар батлах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, Засгийн газрын 2023 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам"-ын 5.10, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, "Боловсролын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлд өгөх зөвлөмж, албан даалгавар"-ыг хоёрдугаар, "Сангийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлд өгөх зөвлөмж, албан даалгавар"-ыг гуравдугаар, "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлд өгөх зөвлөмж, албан даалгавар"-ыг дөрөвдүгээр, "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлд өгөх зөвлөмж, албан даалгавар"-ыг тавдугаар, "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлд өгөх зөвлөмж, албан даалгавар"-ыг зургаадугаар, "Эрүүл мэндийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлд өгөх зөвлөмж, албан даалгавар"-ыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг улирал тутамд тайлагнаж ажиллахыг дэд болон салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Яамдын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зардлын ангиллыг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлд чиглэл хүргүүлэхийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн гишүүн /Ж.Ганбат/-д даалгасугай.

4. Сонсголын үр дүнд гаргасан зөвлөмж, албан даалгаврыг дэд зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусган, шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажиллахыг зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Дэд болон салбар зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлд танилцуулахыг Зөвлөлийн ажлын алба (З.Бауыржан)-д тус тус даалгасугай.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ
ХАНГАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ЭНХ-АМГАЛАН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

З.БАУЫРЖАН

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээний чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Төсөв (сая төгрөг)	Төсөв хариуцах байгууллага	Хариуцах зөвлөл	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
		I	II	III	IV						
НЭГ. БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮРЭЭНД:											
1.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Саадгүй байдал, хүртээмжийн тухай, Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;					Хуулийн төсөл	2	50,0	ГБХНХЯ	ГБХНХЯ	Яамд
1.2	Үйл ажиллагааны олон улсын үйлдлийн ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах					Хэлэлцүүлгийн тоо	3	-	ОУБ	ГБХНХЯ ЭМЯ	ХБХХЕГ ТББ
1.3	УИХ-ын чуулганаар хэлэлцэн батлах холбогдох хууль тогтоомжийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой асуудлаар санал хүргүүлэх /Төрийн албаны тухай хууль/					Хүргүүлсэн санал	1	10,0	ГБХНХЯ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	ХЗДХЯ, ГБХНХЯ
1.4	Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан үндэсний стратегийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх					Стратегийн төсөл	1	20,0	ГБХНХЯ	ГБХНХЯ	ТББ
ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД											
2.1	Яамдын 2026 оны төсөвт эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллын					Төсвийн ангилалтай болсон яамны	10	-	-	СЯ	Бүх дэд зөвлөл ТББ

	асуудлаар хөрөнгө тусгуулах ажлыг зохион байгуулах				тоо					
2.2	Засгийн газар, Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болон хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэл сонсох, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлд үзүүлэх үр нөлөөг сайжруулах чиглэлд санал, зөвлөмж өгөх				Зөвлөмжийн тоо	1	10,0	ЭЗХЯ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	ЭЗХЯ
2.3	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд суурилсан загвар” сургалтын багц модуль боловсруулах				Сургалтын модулын тоо	1	20,0	ХБХХЕГ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	ГБХНХЯ
2.4	Хөгжлийн бэрхшээлийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн талаар цахим сургалтын хөтөлбөр боловсруулж, төрийн албан хаагчдыг хамруулах				Сургалтын хөлбөрт хамрагдсан хүний тоо	500	30,0	ХБХХЕГ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	ГБХНХЯ
ГУРАВ. ДЭД, САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХҮРЭЭНД:										
3.1	“Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-ийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах				Зохион байгуулсан арга хэмжээ	1	150,0	ХБХХЕГ	Зөвлөлийн ажлын алба	ГБХНХЯ Дэд, салбар зөвлөлүүд
3.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенцын зөвлөмжийг хэрэгжүүлэх, сурталчлах				Зөвлөмжийн тухайн жилийн хэрэгжилтийн хувь	80	50,0	Яамд, аймаг	Дэд, салбар зөвлөл	ГБХНХЯ ХБХХЕГ ТББ
3.3	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл болон Засгийн газрын 2022 оны 253 тогтоолын хэрэгжилтийн талаар Улсын үзлэг зохион байгуулах				Гүйцэтгэлийн хувь	100	200,0	ГБХНХЯ	Дэд, салбар зөвлөл	ГБХНХЯ ХБХХЕГ ХХҮЕГ
3.4	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн албаны нөөцөд байгаа хөгжлийн				Хуулийн хэрэгжилтийн хувь	90	-	Яамд, аймаг	Дэд, салбар зөвлөл	Төрийн албаны зөвлөл

	бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах ажлыг зохион байгуулах									Зөвлөлийн ажлын алба	
3.5	ГБХНХЯ, ЗТЯ, ХЗДХЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, ЭЗХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн тайланг хэлэлцэх Сонсгол зохион байгуулах					Сонсгол зохион байгуулсан тайлан, зөвлөмж	6	30,0	ГБХНХЯ ХБХХЕГ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	ГБХНХЯ, ЗТЯ, ХЗДХЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, ЭЗХЯ
3.6	Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн тайланг хэлэлцэх Сонсгол зохион байгуулах					Сонсгол зохион байгуулсан тайлан, зөвлөмж	6	60,0	ГБХНХЯ ХБХХЕГ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	Архангай, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл, Хэнтий
3.7	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нөлөөллийн сургалтыг зохион байгуулах					Сургалтад хамрагдах албан хаагчдын тоо	2000	100,0	Яам бүр	Дэд, салбар зөвлөл, ХБХХЕГ	ТББ
3.8	Дэд болон салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах					Сургалтын тоо	8	20,0	ГБХНХЯ ХБХХЕГ	ТББ, Зөвлөлийн ажлын алба	ГБХНХЯ
3.9	ТББ-аар гэрээлэн гүйцэтгэх боломжтой ажил, үйлчилгээний жагсаалтыг гаргаж, цахим хуудсанд ил тод байршуулах, хэрэгжүүлэх					Хэрэгжилтийн хувь	100	-	Яам, аймаг	Дэд, салбар зөвлөл	ХБХХЕГ
3.10	Салбарын хэмжээнд гурваас доошгүй байгууллагын хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах					Хэрэгжилтийн хувь	100	-	Яам, аймаг	Дэд, салбар зөвлөл	ХБХХЕГ
3.11	Салбарын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэг болон төрийн албаны нөөцөд бүртгэлтэй байгаа, сургалт, төсөл, хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн					Статистик мэдээлэл	10	-	Яам, аймаг	Дэд, салбар зөвлөл	ТББ

	бэрхшээлтэй иргэдийн судалгаа, статистикийг бэрхшээл, хүйсээр гаргах маягыг батлан үйл ажиллагаандаа ашиглах										
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

—oOo—